

УРАН ЗОХИОЛ ДАХЬ ФИЛОСОФИ ИЛРЭЛ

Б.Дэлгэрмаа (Ph.D)

МУИС, НШУС,

Философийн Тэнхим

Б.Дэлгэрбаяр (МА, цагдаагийн дэслэгч)

Хууль Сахиулахын Их Сургууль

Түлхүүр үг: *экзистенци, абсурд, хүний амьдралын утга учир, ёс суртахуун, эгоизм*

Гол утга: *Бидний өгүүллийн зорилго нь уран зохиолын бүтээлүүдэд философи үзэл санаатай ямар ямар бүтээлүүд байгааг олж илрүүлж тайлбарлах, анализ дүгнэлт хийхэд оришиж байгаа юм.*

Уран зохиолд философийн асуудлуудыг хөндсөн олон арван бүтээл байдаг. Орчин үед философи, уран зохиол хоёр нэгдмэл байдлаар хөгжих боллоо. Францын зохиолч, философич Ж.П.Сартр, А.Камю, Вольтер, Д.Дидро, Германы соён гэгээрүүлэгч, философич Й.В.Гёте, Ф.Шиллер, Оросын зохиолч, философич Ф.М.Достоевский, А.П.Чехов, Л.Н.Толстой, Чехийн зохиолч Ф.Кафка, Ирландын зохиолч Ж.Жойс, С.Беккет, Румыны зохиолч Э.Ионеско, Америкийн зохиолч М.Норман, Австрийн зохиолч П.Туррини, Колумбын зохиолч Г.Маркес, Америкийн зохиолч А.Рэнд зэрэг зохиолчид философи агуулгатай уран зохиолын бүтээлийг олныг туурвисан байдаг. Тухайлбал, Ж.П.Сартрын “Үг”, “Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн”, “Огюдас”, А.Камюгийн “Этгээд хүн”, “Тахал”, Вольтерын “Жамаараа яваа ертөнц”, “Задиг буюу хувь тавилан”, “Кандид буюу өөдрөг санаа”, Д.Дидрогийн “Гэлэнмаа”, И.В.Гётегийн “Фауст”, Ф.М.Достоевскийн “Гэм зэм”, “Дорд үзэгдэгсэд”, “Ах дүү Карамазовынхон”, Л.Н.Толстойн “Дайн ба энх”, А.П.Чеховын “Хамелеон”, “Баг”, “Бүдүүн нарийн хоёр”, “Турлиах”, “Дугтуйтай хүн”, “Зургадугаартасаг”, Ф.Кафкагийн “Шүүхажиллагаа”, Ж.Жойсын “Үлисс”, “Дүблинчүүд”, Г.Маркесын “Зуун жилийн ганцаардал”, А.Рэндийн “Бид амьд хүмүүс”, “Магтуу”, “Атлантын нуруу тэнийв” зэрэг зохиолууд нь философийн асуудлуудыг хөндсөн бүтээлүүд юм. Зарим жишээг авч үзье.

Францын философич Вольтерын (1694-1778) “Жамаараа яваа ертөнц”, “Задиг буюу хувь тавилан” зохиолууд нь ертөнцийн жам ёсны тухай философи асуудлыг дүрслэн гаргажээ. Вольтер энэ ертөнцөд сайн муу, сайхан муухай, шударга ба шударга бус зүйл аль аль нь оршин байдаг болохыг өөрийн зохиолоор харуулжээ. Энэ талаар Вольтер “Задиг буюу хувь тавилан” зохиолдоо “Задиг аз жаргал гэдэг байгаль ертөнцийг судлан танихад байна гэж ухаарчээ. Бурхан тэнгэрийн бидэнд хайрласан энэ зузаан номыг уншигч гүн ухаантнаас өөр аз жаргалтан гэж байхгүй. Гүн ухаантны таньсан үнэн өөрт нь л хэрэг болно, гүн ухаантан тийнхүү сэтгэл юугаа зогоож тэтгэнэ, тайван амьдарна...”¹ гэж бичсэн нь аз жаргал гэдгийг байгаль, ертөнцийг таньж мэдэх явдал хэмээн үзэж, аз жаргалтай хүний жишээгээр ном уншин суудаг философич хүнийг авч үзжээ. Мөн цааш нь “Юмыг их мэднэ гэдэг заримдаа юутай осолтой байдгийг Задиг ухаарч авав. Тэгээд дараагийн удаа үзсэн харснаа дуун дээр хэлэхгүй юм шүү гэж өөртөө тангараглажээ... “Их тэнгэр минь, хатан хааны жингэрээс болж, бас хааны морь явж өнгөрсөн ой модонд салхинд гарснаас харамсахад хүрэв. Цонхоор харах ч мөн осолтой ажээ! Ер нь энэ

1. Вольтер. Жамаараа яваа ертөнц. УБ., 2009 он, 204 дэх талд

ертөнцөд аз жаргалтай явна гэдэг амаргүй юм шив дээ” гэж боджээ”² хэмээн өгүүлсэн нь, ертөнцөд эсрэг тэсрэг талууд зэрэгцэн оршиж байдаг, ертөнцөд зовлон жаргал ээлжлэн оршин байдаг философийн асуудлыг уран сайхны аргаар үзүүлсэн байна. Ийнхүү Вольтер уран зохиолын бүтээлээр өөрийн философи үзэл санааг илэрхийлэн гаргажээ.

Ирландын зохиолч Ж.Жойсын “Дүблинчүүд” зохиол нь дотроо 15 өгүүллэгээс бүрддэг. Эдгээр өгүүллэгт Ирландын нийслэл Дүблин хотынхны амьдралыг харуулж, экзистенциалист философи, ёс суртахууны философийн асуудлуудыг хөндөж тавьсан байна. Жишээ нь, “Эгч дүү” өгүүллэгт Жэймс Флинн ламтанг нас барсан тухай, түүнийг оршуулах ёслолд хүрэлцэх ирсэн хэд хэдэн хүний бодрол гардаг. Энэ өгүүллэгт хүн үхнэ гэдгээ мэддэг хэдий ч амьдрахыг хүсдэг, амьдрахдаа утга учиртай амьдрах нь чухал юм гэдэг философи асуудлыг илэрхийлж гаргасан байна. Жэймс Флинн ламтаныг тийм ч сайнаар боддоггүй боловч нийгэмд тогтсон хандлага, ёс заншлын дагуу оршуулах ёслолд очиж, дотор сэтгэлдээ огт харамсахгүй, тэнд буй хүмүүсийн яриаг үл тоомсорлох залуугийн дүрээр хүний ёс суртахууны болоод хүний мөн чанарын асуудлыг дэвшүүлжээ. Эгоизм буюу хувна хичээх үзэл, ёс суртахуунаа гээж байгаа хүмүүсийн бодит амьдралын үнэнийг үгийн урлагаар харуулжээ.

Ж.Жойс “Золгүй явдал” өгүүллэгтээ экзистенцийн асуудал, орчин үеийн хүний ганцаардлын тухай асуудлыг хөнджээ. Хүмүүс хот суурин газар бөөнөөр суурьшин амьдарч хөгжиж байгаа мэт боловч үнэн хэрэгтээ хүн ихээхэн ганцаарддаг болох тухай өгүүлжээ. Энэ зохиолын гол дүр ноён Даффи ганц биеэрээ амьдардаг боловч нөхөртэй эмэгтэй хатагтай Синикотой уулзаж хайр дурлалын холбоотой болж байгаа тухай гарна. Тэд дахин уулзахгүй байхаар шийддэг. Ингээд уулзахаа больсоноос хойш 4 жилийн дараа хатагтай Синико галт тэргэнд дайруулж амиа хорлож үхсэн тухай ноён Даффи сониноос олж мэддэг. “...Аливаа холбоо сүлбээ зовлон авчирдаг юм гэж тэр хэлэв. Цэцэрлэгт хүрээлэнгээс гараад тэд трамвайн зогсоол руу дуугүйхэн явцгаав, гэвч гэнэт тэрээр хүчтэйхэн чичирч эхэлсэн тул түүний зүгээс дахин ямар нэг нялцгар, салж ядсан байдал илрэх вий гэхээс эмээж, түүнийг орхин бушуухан явж оджээ...”³. “Энэхүү нүгэлт, нууцлаг хайр түүний сэтгэлийг харууслаар дүүргэнэ. Ёс зүйн тогтвортой байдлыг үзэн ядаж, өөрийгөө тэр амьдралын баяр баяслаас бүрмөсөн холдсон мэт мэдэрч байлаа. Ганцхан хүн түүнийг хайрласан билээ, харин тэр амьдрал хийгээд аз жаргалыг бэлэглэхээс татгалзсан. Түүнийг тэр гутамшиг хийгээд ичгүүртэй үхлээр ялласан...”⁴. Жойс энэ зохиолдоо хайр бол ганц л байдаг тухай өгүүлсэн төдийгүй нийгмийн хүлээсэнд хайрлах сэтгэлээ нууж, эцэст нь энэ бүхэн эргээд амьдрах хүсэлгүйд хүргэж, амиа хорлож буй бүсгүйн дүрээр нийгэмд байх ёстой ёс суртахуун нь хүний хувийн оршихуйд халдаж байгааг харуулсан. Өөрийн Би-г дээдлэх үзлээс хол байж, нийгэмд байх хэм хэмжээг дагаснаар өөрсдийн хүсэл тэмүүлэлд цэг тавьж, үүнээс үүдэн амьдрах хүсэлгүйд хүрч байгаа нь нийгэм болон хувь хүний хоорондын зөрчлийг харуулсан байна.

Ж.Жойс “Үлисс” зохиолдоо Блум, Стивен, Молли нарын дүрээр, тэдний бодрол, зүүд зэргээр эцэг хүүгийн болоод, эхнэр нөхрийн хоорондын харилцааны нарийн ээдрээтэй холбоо хамаарлын асуудлыг уран сайхны аргаар харуулж, ёс суртахууны философи, психоанализ, экзистенциализмын философийн үзлийг хөндөж тавьсан гэж үзэх нь зүйтэй юм. ХХ зууны хүн төрөлхтний оюун санааны амьдралд Ж.Жойсын уран бүтээлүүд нь шуугиан тарьсан үзэгдэл байсан юм. Жойс өөрийн уран бүтээлээрээ орчлон ертөнц хязгааргүй, хүний оюун санаа шавхагдашгүй гэдгийг харуулахыг оролдсон байдаг. Зохиолын баатруудынхаа дотоод сэтгэлийг нээж гаргахдаа бүрэн ухамсарлагдаагүй бодол санааны эмх замбараагүй урсгалыг үзүүлдэг. Тэрээр ухамсрын урсгалаар зохиолоо туурвидаг хийгээд, ухамсарт чанарыг ухамсарт бус чанартай нь сөргөлдүүлдэг. Жойс өөрийн зохиолууддаа орчин үеийн хүний хувь заяаны асуудал, хүний мөн чанар, хүний амьдралын утга учрын тухай зэрэг философийн асуудлыг

2. Мөн тэнд, 206-207 дахь талд

3. Жэймс Жойс. Дүблинчүүд. УБ., 2010, 154 дэх талд

4. Мөн тэнд, 160 дахь талд

илэрхийлэн гаргадаг. Өөрөөр хэлбэл, Жойс экзистенциалист философи, эгоизм, абсурд, ёс суртахууны философийн асуудлыг уран бүтээлээрээ гаргасан юм.

Францын философич Ж.П.Сартр "Огнудас" романаараа экзистенциалист философийн үзэл санаагаа илэрхийлэн гаргажээ. Уг роман бол хүний эрх чөлөөг чухалчилдаг. Эрх чөлөө бол ганцаардал, бусдаас ангид байх явдал гэж үзжээ. Энэ утгагүй хоосон ахуйн огнудас хүрэм байдлаас гагцхүү Урлаг л хүнийг татан гаргах боломжтой гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Романы гол дүр Антуан Рокантен гадаадын улс орнуудаар хэрэн тэнэсэн хүн бөгөөд түүний өдрийн тэмдэглэл маягаар уг зохиол бичигджээ. Энэ зохиолд гол баатар Антуан 1932 оны 1-р сараас эхлэн гэнэт өөрийгөө өөрчлөгдөөд буйг мэдэрнэ. Тэрээр галзуурах гээд ч байгаа юм шиг, зарим үед дотор нь муухайран огнудас нь хүрэх болжээ. Рокантен хүн амьд явах нь ямар ч утга учиргүй гэж үздэг хүн юм. Огнудас өөрөөсөө үнэнийг төрүүлж байна. Огнудас нь гадаад ертөнцийг, материаллаг ертөнцийг хөдөлбөргүй зүйл мэтээр хүлээж авах бүр улам бүр нэмэгдэх, дээд цэгтээ хүртэл хурцадсан, гансарсан сэтгэлийн үр дагавар юм. Болохгүй байгаа нийгмийг харах бүр, жүжиглэн амьдарч байгаа хүмүүсийг харах бүр түүний огнудас хүрч нь байна. Романы төгсгөлд Рокантен гэнэтхэн сэхээ орж, өөртэйгээ, амьд яваатайгаа эвлэрэх аргыг олж харах шиг болно. Ингээд тэр зохиол бичихээр шийднэ. Энэ аугаа уудам ертөнц дээр хэн нэгэн хүн бичсэн зүйлийг нь олж уншвал Рокантен аз жаргалтай байх болно. Энэ талаар зохиолд "Ном. Роман. Роман уншчихаад "Энийг Антуан Рокантен гэдэг хонгор үстэй, нэг кафегаас нөгөө кафе руу сэлгүүцэж явдаг байсан залуу бичсэн юм" гэж хэлэх хүмүүс олдож л таарна...Ном бичнэ. Ажил мэдээж маш хүнд, тамир барам байх болно. Ажил намайг оршихуйгаас ч, оршин буй гэдэг ухамсраас ч ангижруулахгүй. Гэвч номоо бичиж дуусаж, ном ард хоцрох хором ирнэ. Тэр цагт миний өнгөрсөн үл ялигаар, тун багаар гэгээ татаж эхэлнэ гэдэгт би итгэж байна. Магадгүй, энэ гэгээгээр дамжуулан би өөрийнхөө амьдралыг ой гуталгүйгээр эргэн дурсаж чадах болно..."⁵ хэмээн өгүүлсэн нь хүний философи, экзистенциализмын философийн асуудлыг харуулжээ.

А.Камю "Тахал" зохиолдоо 1940-өөд оны үед тахлаас болж Алжирийн эрэгт орших Оран хэмээх нэгэн хотод учирч байгаа гай гамшиг, хор хөнөөлийг үзүүлсэн. Бернар Риз эмч тахлын эсрэг арга хэмжээг удирдаж буй хүн юм. Зохиолд мөн хотын захиргааны албан хаагч Гран, түүний хөрш Коттар, францаас ирсэн Раймон Рамбер, Жан Тарроу зэрэг дүрүүд гарна. Тахлын улмаас маш олон хүн нас барж, гамшиг нь дээд цэгтээ тулж байхад, сэтгэл хангалуун байсан цорын ганц хүн бол Коттар юм. Тэрээр тахлын үед цагдаагийн газраас айх аюулгүй болж, хүмүүсийн зовлонг ашиглан хөлжиж байна. "Тахал" роман нь харгислал хүчирхийллийг эсэргүүцэн сөрөх, хамгийн хүнд бэрх үед ч сайн үйлс бүтээх хүний чадвар, мөн бусдын зовлонг өөрийн амин зуулганд ашиглах завшаанч үзлийг харуулжээ. Энд утга учиргүйдлийг тэмцэлтэй холбож тайлбарласан. "Тахал" роман бол хүн төрөлхтөн зовлон гамшигт хэзээ ч юм учирч болзошгүй юм гэдгийг дүрслэн үзүүлснээрээ хүн төрөлхтний оршихуйн асуудлыг харуулсан экзистенциалист философийн зохиол юм.

Францын орчин үеийн философич А.Камюг иррационалист философийн нэг томоохон төлөөлөгч гэж үздэг. Камю хүний оршихуйн утгагүй байдлыг "Этгээд хүн" туужийнхаа гол баатар Мерсогийн амьдралаар дүрслэн үзүүлсэн юм. Мерсо бол ээж нь нас барчихаад байхад нэг их гашуудахгүй байгаа, оршуулганд яваад ирчихээд найз хүүхэнтэйгээ кино үзээд явж байдаг этгээд хүн юм. Найз хүүхэн нь өөртэй нь гэрлэх тухай ярихад "чи үнэхээр хүсэж байвал гэрлэсэн ч яахав" гэх зэргээр ярьж байгаа, өөрт нь бараг хамаагүй хүнийг учир утгагүйгээр буудаж байгаа зэрэг үйл явдлууд зохиолд гарна. Мерсо бол жинхэнэ абсурд хүн юм. Камю "Этгээд хүн" зохиолоороо экзистенциализм, абсурдын философийг харуулсан юм.

Германы их зохиолч Й.В.Гёте (1749–1832) "Фауст" зохиолынхоо санааг 1770-аад оны үед олоод насан туршдаа бичсэн гэдэг. Өөрөөр хэлбэл, зөвхөн энэ зохиолыг бичихийн тулд 60-аад жилийг зарцуулжээ. Зохиолын эхний хэсэг нь 1808 онд хэвлэгдэж, хоёр дахь хэсгийг 1827

онд бичжээ. Төгсгөлийн хэсгийг Гёте нас барахынхаа өмнө 1831 онд дуусгаж, зохиол 1833 онд хэвлэгджээ. Фауст бол түүхэн бодит хүн юм. XVI зууны үед амьдарч байсан доктор Фаустын тухай элдэв домгууд байдаг. Түүнийг анх уран зохиолд оруулж ирсэн хүн бол Шекспирийн үеийн зохиолч Кристофер Марло юм. Түүний 1604 онд бичсэн “Доктор Фаустын эмгэнэлт түүх” (“The tragical History of Doctor Faustus”) хэмээх жүжиг байдаг. Үйл явдлын хувьд эдгээр жүжгүүд ойролцоо юм. Гёте өөрийн зохиолдоо доктор Фаустын амьдралын 5 үеийг 5 бүлгээр харуулсан. Гёте “Фауст” эмгэнэлт жүжгээрээ хүн төрөлхтний хөгжлийн тухай асуудал, хүний амьдралын утга учир, цаг хугацаанаас ангид орших ертөнцийн загварыг дүрслэн үзүүлсэнээрээ хүний философи, хөгжлийн философи, цаг хугацааны философи асуудлуудыг гаргасан юм. Диваажин, Там, Газар дэлхийн амьдралыг Гёте харуулсанаараа шашны философийн асуудлыг хөнджээ. Зохиолын эхэнд Фауст:

“Түн ухаан, хууль цааз, анагаах ухаан

Гүйцэд биш гэсэн шинг бас шашны номыг

Хичээнгүйлэн нэвт шувт судлав,

Өмнөхөөсөө би харин ухаан нэмсэн билүү?

Элдэв эрдмийн цол ч хүртэв,

Эргээд надад тус болох нь юу л бол”⁶ хэмээн өгүүлж байна. Фауст ажлын өрөөндөө он удаан жил суусны эцэст хүний таньж мэдэх бүхний оройд хүрчээ. Дараа нь хамгийн учир битүүлэг үзэгдлүүдийн нууцыг тайлахаар шийдэж, ид шид болон алхимийг сонирхож эхэлжээ. Энэ бүхний эцэст нас тогтсон хойноо таашаал жаргалыг бус, үргүй дэмий чармайлтаас үүдсэн зовлон шаналыг мэдэрчээ. Фауст ертөнцийн бүхий л нууцыг шинжлэх ухааны хүчээр таньж мэдэж болохгүйг ухаарч, хүний мэдлэг хязгаарлагдмал болохыг мэднэ.

Оросын алдарт зохиолч А.П.Чехов “Хамелеон”, “Баг”, “Бүдүүн нарийн хоёр”, “Дугтуйтай хүн”, “Турлиах” зэрэг богино өгүүллэгүүддээ хүний философи, нийгмийн философи асуудлыг тусгажээ. “Турлиах” өгүүллэгт “Турлиах: -Эрхэмсэг хүн гуай минь, ухаан гэдэг чинь насны урт богиноос биш, хүмүүжил боловсролоос шалтгаалдаг юм шүү. Бид тэнэг, гэвч амьдралынхаа 400 жилд бидний хийсэн мунхаг тэнэг зүйлс нь хүн амьдралынхаа 40-хөн жилд хийсэн мунхаг үйлээс хамаагүй бага гэж бодоход бас сэтгэлээ тайвшруулж болох юм. Би 376 нас наслахдаа турлиахууд өөр хоорондоо байлдаж юм уу алалцахыг огт үзсэнгүй. Харин дайнгүй өнгөрч байсан жил дайралдсан эсэхийг та санаж байна уу? Бид бол бие биесээ тонодоггүй, шахан хавчдаггүй, муу муухай роман болон шүлэг бичдэггүй, зүхэн занасан сонин хэвлэдэггүй, зарц зусар бялдууч нар байдаггүй юм гэлээ”⁷ хэмээн бичсэн байгаа нь хүний амьдралыг турлиах шувууны амьдралтай харьцуулан, хүн турлиах шувууг бодвол маш богинохон насалдаг, гэвч энэ насандаа хүмүүс муу муухай зүйл их хийдэг, хүмүүс амьдралдаа бие биесээ шахан хавчдаг, хүмүүс хоорондоо дайн тулаан хийдэг, хүн хүндээ бялдуучилдаг болохыг харуулжээ. Энд цаг хугацааны философи, оршихуйн философи илэрч байна. Чехов “Хамелеон” зохиолдоо генерал Жагеловын нэрийг сонсонгуутаа тэр дороо хувирч байгаа түшмэл Очумеловын дүрээр, “Баг” өгүүллэгтээ саятан Пятигоровт багаа авангуут нь таньж долигонон байгаа Жестяков, Евстрат Спиридоныч нарын дүрээр, “Бүдүүн нарийн хоёр” зохиолдоо нарийн нь бүдүүндээ долигонож байгаа байдлаар энэ нийгэмд өөрийнхөө байгаагаараа байдаггүй, шарыг харж шарваж, улааныг харж урваж хамелеон маягаар амьдардаг хүн, жүжиглэж амьдардаг хүн хичнээн олон болохыг дүрслэн илэрхийлжээ. Ёс суртахууны философи, нийгмийн философи асуудлууд Чеховын зохиол бүтээлээс харагддаг юм.

Орос гаралтай Америкийн зохиолч Айн Рэнд нь өөрийн бүтээлүүдээрээ “Эго центризм” буюу “Би төвт үзэл”-ийн философийг баримтлан сурталчилдаг. Өөрөөр хэлбэл, хувь хүнийг, түүний бусдаас ялгарах шинж чанар, хүрээлэлдээ эзлэх байр суурь, үүргийг нэн тэргүүнд тавьж, “хүн бол нийгмийн амьтан”, “хувь хүн хамт олны дунд хүмүүжнэ” гэсэн уламжлалт үзлийг

6. Й.В.Гёте. Фауст. УБ., 2009 он, 18 дахь талд

7. А.П.Чехов. Интоорын цэцэртэг. УБ., 2009 он, 273 дахь талд

шүүмжилж байжээ. Түүний философийн гол утга нь “ах дүүгийн барилдлага”, “интернационалч үзэл”, “хамт олонч зан чанар”, “намын үзэл баримтлал” зэрэг уриа лоозонгийн оронд “үндэс утсаа, эцэг дээдсээ хүндлэн бишрэх”, “амин хувийн хариуцлага”, “хувь хүний чадвартай байдал” зэрэг ойлголт, хувь хүний чадварыг чухалчилдаг. Хүн байх нь юуны өмнө, амин хувийн сайн сайхан байдал, амьдралын төлөө тэмцэх чадварын тухай асуудал ба энэ чадвар нь бодгаль хүн болгонд харилцан адилгүй учраас хувь хүн бүр дахин давтагдашгүй шинжийг агуулдаг. “Миний хурууны хээ давтагдашгүйн нэгэн адил би өнө мөнхийн давтагдашгүй”, “Намайг хэн ч, хэзээ ч бүрэн бүтнээр минь орлож үл чадна” гэсэн зарчим, үзэл бодол бид бүгдийн сэтгэл зүрхэнд ноёрхож байх ёстой. Энэ бол амьд хүн бүрийн бахархал юм”⁸. Нийгэм бол хосгүй шинж чанар, авьяас чадвар бүхий хувь хүмүүсийн бөөгнөрөл, нэгдэл байдаг билээ. Айн Рэндийн философи XX зууны эхэн үе дэх Оросын түүхэн үйл явдлын нөлөөн дор бүрэлдэн төлөвшжээ. Түүний анхны бүтээл “Бид амьд хүмүүс” романд 1920-иод оны ЗСБНХУ-д тохиосон эмгэнэлт үйл явдлуудын тухай өгүүлдэг. Энд төр улс ба бие хүн хоёрын, нийгмийн сайхан сайхан ба хувь хүний аз жаргал хоёрын эсрэг тэсрэг шинж чанарыг харуулжээ. Петроград-Ленинград хотын ахуй амьдралын адармаат үйл явдлуудаар дамжуулан, хүмүүс найз нөхдөө худалдах, үйл хэргээсээ урваж байгаа зэргийг дүрслэн үзүүлсэн байна. А.Рэндийн бүтээлүүд эгоизмын философи, хувь хүний бодгаль зарчмыг сурталчилдаг.

Оросын агуу их яруу найрагч А.С.Пушкин (1800-1837) маш богино насалсан хүн боловч тэрээр дэлхийн хэмжээнд нэр алдар нь түгсэн зохиолч билээ. Пушкин “Хөшөө дурсгалаа босгов, би” шүлэгтээ:

“Харь Александрын сүлд баганаас өндөрт
Халдашгүй тэргүүнт хөшөөгөө босголоо
Эгэл гар бүтээшгүй эрхэм дурсгалыг минь
Эгээрэн зорих ардын зам эдгэхгүй ээ!
Үгүй ээ, би бүр үхэхгүй!
Хүслэнт найрагтаа шингэж
Үгүйрэх замыг цуцална, үхдэл биеэ элээн!
Ялгуун саран дор ядаж ганц найрагч үлдэхэд л
Яруу алдрын суу миний нэрийг дагана!
Зах хяргахгүй Оросоор зар цуу минь түгнэ.
Зам гудсаар хэлтэн бүрт нэр минь хүрнэ.
Омогт славян үр сад, сами, талын анд халимаг,
Ойд аглаг суугаа хамнигад хүртэл нэрлэнэ.
Энэрэлгүй хахир цагт эрх чөлөөг алдаршуулж
Элэг нинжин сэтгэл аялгуут найргаар сэрээж
Эрхшээлд сөгдөн дордост өршөөл нэхсэнээрээ
Эрин эринд би ард түмэндээ дурсагдана!

Эгшиг минь! Тэнгэрийн тааллыг л дага даа!” хэмээн бичсэн нь амьдралын философи асуудлыг тусгажээ гэж үзэж болно. Хүн нь өөрөө үхэвч бүтээл нь мөнх юм. Энэ шүлэгт цаг хугацааны философи, хүний оршихуйн философи илэрч байна.

1837 оны 1-р сард Оросын агуу яруу найрагч А.С.Пушкин дуэльд алагдсанд ихээхэн харамсаж М.Ю.Лермонтов (1814-1841) “Яруу найрагчийн үхэл” гэдэг шүлэг бичсэн нь түүнийг Оросын тэргүүн зэргийн яруу найрагч болгосон юм. Лермонтовын энэ шүлгийн зарим хэсгээс бичье:

“Алдар хүндийн боол нас баржээ.
Авиа ихтэй цуу гүтгэлгэнд унажээ.
Цээжиндээ тугалга зоолгоод хонзонгоор буцалсаар

8. Айн Рэнд. Бид амьд хүмүүс. УБ., 2012 он, 6 дахь талд

Чин зоригт тэргүүнээ даржээ...

Эзэн ширээний дэргэд хомхойрон хуйлрагчид та нар

Эрх чөлөө, суу заль, алдар гавьяаны яргачид мөн.

Та нар хуулийн саравчинд хоргодоцгоо

Та нарын өмнө үнэн ба шүүх байна. Бүү дуугарцгаа.

Байна, бурханы шүүх байна, самууныг таригчид аа.

Байх байхдаа догшин шүүгчид байна тэр хүлээж байна.

Сайхан алтны жингэнэх дуунд тэр худалдагдахгүй.

Санаа хэрэг хоёрыг урьдаас мэддэг юм...

Аль байдаг хар цусаараа тургивч та нар

Ариун шударга шүлэгчийг бузарлаж чадахгүй”⁹ хэмээн Д.Сэнгээ орчуулсан юм. Оросын их яруу найрагч М.Лермонтов улс төрийн философи, шударга үнэний философи, эрх чөлөөний философи асуудлыг өөрийн шүлэг найраглалаараа гаргасан юм. Лермонтов мөн их богино насалсан боловч дэлхийд алдаршсан зохиолч болж чаджээ.

Ийнхүү шүлэг, яруу найраг, уран зохиолд философийн асуудлуудыг тусгасан бүтээлүүд олон байдаг юм.

НОМ ЗҮЙ

1. Айн Рэнд. Бид амьд хүмүүс. УБ., 2012 он
2. Вольтер. Жамаараа яваа ертөнц. УБ., 2009 он
3. Й.В.Гёте. Фауст. УБ., 2009 он
4. Б.Дэлгэрмаа. Урлагийн философи. УБ., 2012 он
5. Жэймс Жойс. Дүблинчүүд. УБ., 2010 он
6. С.Лочин. Оросын уран зохиолын цоохор тэмдэглэлээс. УБ., 2011 он
7. Ж.П.Сартр. Огнудас. УБ., 2010 он
8. А.П.Чехов. Интоорын цэцэрлэг. УБ., 2009 он

РЕЗЮМЕ

В этой статье показывается о философии в литературе. Во многих произведениях раскрываются о проблемах философских в литературе. В произведениях французских философов Ж.П.Сартра, А.Камю, Вольтера, русских писателей и философов Ф.М.Достоевского, А.П.Чехова, Л.Н.Толстого, Ирландских писателей Ж.Жойса, С.Беккета и Американских писателей М.Норман, А.Рэнда подчёркивают философских проблемах о сущности человека, о значении человеческой жизни, об эгоизме, об асурде и об этической философии.